

I-III/2021

Тархаасан: 2021 оны 4 дүгээр сарын 12




Улсын хилээр орсон гадаадын зорчигчид өмнөх оны мөн үеэс 37.1 мянга буюу 90.2 хувиар буурчээ.

Манай улсын хилээр 2021 оны эхний улиралд 189.9 (давхардсан тоогоор) мянган зорчигч нэвтэрсэн нь өмнөх оны мөн үеэс 362.0 (65.6%) мянгаар буурчээ.

Манай улсын хилээр 2021 оны эхний улиралд 95.6 мянган зорчигч орсон байна. Улсын хилээр орсон зорчигчдын 33.9 хувь нь Гашуун сүхэйт, 24.7 хувь нь Шивээ хүрэн, 15.3 хувь нь Замын-Үүд, 6.3 хувь нь Буянт-Ухаа, 1.7 хувь нь Алтанбулаг, 18.1 хувь нь бусад боомтоор орсон байна.

Улсын хилээр орсон зорчигчдын 91.6 (95.8%) мянга нь Монгол Улсын иргэд, 4.0 (4.2%) мянга нь гадаад улсын иргэд байна.

Зураг 1. Монгол Улсын хилээр орсон зорчигчид, боомтоор, дүнд эзлэх хувиар, жилийн бүрийн эхний улирлын байдлаар



Коронавируст халдвар (COVID-19) дэлхий дахинд гарсантай холбогдуулан Монгол Улсын хилийн боомтуудыг 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрөөс хааж эхэлсэн. Энэ оны 1-р сард Монгол Улсын 748 иргэн тусгай үүргийн нислэгээр, 4 иргэн авто зам болон төмөр замын боомтуудаар, 2-р сард Монгол Улсын 1 195 иргэн тусгай үүргийн нислэгээр, 65 иргэн авто зам болон төмөр замын боомтуудаар, 3-р сард Монгол Улсын 2 076 иргэн тусгай үүргийн нислэгээр, 41 иргэн авто зам болон төмөр замын боомтуудаар тус тус ирсэн байна.

Байтаг, Сүмбэр, Хавирга боомтуудыг 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрөөс, Замын-Үүд, Баянхошуу, Бичигт, Булган, Гашуунсүхэйт, Ханги, Шивээхүрэн болон Буянт-Ухаа боомтуудыг 2 дугаар сарын 15-ны өдрөөс, Алтанбулаг, Арц суурь, Боршоо, Тэс, Ульхан, Ханх, Цагааннуур, Сүхбаатар, Эрээнцав боомтуудыг 3 дугаар сарын 11-ний өдрөөс тус тус хаасан байна.

Улсын хилээр 2021 оны эхний улирлын байдлаар гадаадын 4.0 мянган хүн орсон нь өмнөх оны мөн үеэс 37.1 (90.2%) мянгаар, харин өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 62.9 (94.0%) мянгаар тус тус буурчээ. Тэдний 92.2 хувь нь 30 хүртэл хоног, 0.2 хувь нь 30-аас 90 хүртэл хоног, 7.6 хувь нь 90, түүнээс дээш хоногийн хугацаагаар ирсэн байна. Хилээр орсон гадаадын зорчигчдын 264 (6.6%) нь ажиллах, болон байнга оршин суух зорилгоор, харин 3.8 (93.4%) мянга нь аялал жуулчлалын зорилгоор ирсэн байна.

Аялал жуулчлалын зорилгоор хилээр орсон гадаадын зорчигчид өмнөх оны мөн үеэс 32.7 (89.7%) мянгаар, харин өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 55.1 (93.6%) мянгаар тус тус буурсан байна. Өмнөх оны мөн үеэс БНХАУ-ын жуулчид 5 566 (83.4%), ОХУ-ынх 15 780 (91.5%), Өмнөд Солонгос Улсынх 4 739 (98.0%), Америкийн Нэгдсэн Улсынх 714 (83.5%) хүнээр тус тус буурчээ.

Хүснэгт 1. Монгол Улсын хилээр орсон гадаад зорчигчид, бүс нутаг, улсаар, жил бүрийн эхний улирлын байдлаар

	2018 I-III	2019 I-III	2020 I-III	2021 I-III
Зүүн Ази, Номхон далайн бүс нутаг	50 334	52 594	17 763	1 518
БНХАУ	34 519	34 980	8 139	1 114
БНСУ	7 714	8 084	5 233	140
Казахстан	1 975	2 101	1 349	80
Европ	31 238	31 401	20 851	2 215
ОХУ	26 545	26 582	18 135	1502
Беларус	519	571	572	594
Герман	834	888	460	29
Америк	2 999	3 169	1 475	1 78
АНУ	2 083	2 214	1 083	146
Канад	722	702	276	29
Бразил	56	70	33	2
Өмнөд Ази	440	561	254	71
БНЭУ	329	409	195	71
Иран	29	59	19	-
Балба	18	35	13	-
Ойрх Дорнод	556	374	534	39
Турк	463	246	492	37
Израйл	46	32	20	-
Катар	8	55	11	-
Африк	330	481	284	3
Өмнөд Африк	245	400	243	1
Гана	5	6	9	-
Кени	1	6	8	-
Харьяалалгүй	6	5	2	-
Нийт	85 903	88 585	41 163	4 024

Энэ оны эхний улиралд улсын хилээр орсон гадаадын зорчигчдын 4.0 (98.2%) мянга нь насанд хүрсэн хүн, 73 (1.8%) нь хүүхэд, 3.8 (95.4%) мянга нь эрэгтэйчүүд, 187 (4.6%) нь эмэгтэйчүүд байна.

Улсын хилээр орсон гадаадын зорчигчдын 55.0 хувь нь Европ, 37.7 хувь нь Зүүн Ази, Номхон Далайн бүс нутаг, 4.4 хувь нь Америк, 2.9 хувь нь Ойрх Дорнод, Өмнөд Ази, Африк тивээс иржээ.

Хилээр орсон гадаадын зорчигчдын 27.7 хувийг БНХАУ-ын иргэд, 37.3 хувийг ОХУ-ын иргэд, 3.6 хувийг АНУ-ын иргэд, 3.5 хувийг БНСУ-ын иргэд, 14.8 хувийг Беларус, 2.0 хувийг Казахстан улсын иргэд, 11.1 хувийг бусад улсын иргэд тус тус эзэлж байна.

Манай улсын 89.9

(давхардсан тоогоор) мянган иргэн 2021 оны эхний улиралд гадаадад зорчсоноос 24.7 (27.5%) мянга нь аялал жуулчлалын зорилгоор зорчсон нь өмнөх оны мөн үеэс 160.2 (86.6%) мянгаар буурсан бол 65.1 (72.5%) мянга нь ажиллах, суралцах болон байнга оршин суух зорилгоор зорчсон нь өмнөх оны мөн үеэс 28.5 (77.8%) мянгаар нэмэгдлээ.

Хүснэгт 2. Гадаадад зорчсон Монгол Улсын иргэд, улсаар, жил бүрийн эхний улирлын байдлаар


Очсон улсын нэр	2018 I-III	2019 I-III	2020 I-III	2021 I-III
БНХАУ	394 252	408 383	131 165	85 298
ОХУ	73 418	75 731	44 488	1 523
БНСУ	26 955	23 720	15 766	1 114
Япон	5 901	7 344	3 971	173
АНУ	2 835	3 350	2 045	354

Гадаадад зорчсон Монгол Улсын иргэдийн 87.2 (97.0%) мянга нь эрэгтэйчүүд, 2.7 (3.0%) мянга нь эмэгтэйчүүд, 336 (0.4%) нь хүүхэд байна. Тэдний 88.5 (98.4%) мянга нь 30 хүртэл хоног, 87 (0.1%) нь 30-аас 90 хүртэл хоног, 1.3 (1.5%) мянга нь 90,

түүнээс дээш хоногийн хугацаагаар явсан байна.

Улсын хилээр 2021 оны эхний улиралд 402.3 (давхардсан тоогоор) мянган тээврийн хэрэгслийг нэвтрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 31.0 (8.3%) мянгаар нэмэгджээ. Тэдгээрийн 40.7 хувийг ачааны машин, 0.1 хувийг суудлын машин, 57.9 хувийг ачааны вагон, 1.3 хувийг бусад тээврийн хэрэгсэл эзэлж байна. Нийт тээврийн хэрэгслийн 48.6 хувь нь Замын-Үүд, 15.9 хувь нь Гашуун сухайт, 14.9 хувь нь Сүхбаатар, 11.6 хувь нь Шивээ хүрэн, 0.7 хувь нь Алтанбулаг, 8.3 хувь нь бусад боомтоор тус тус нэвтэрсэн байна.

Зураг 2. Монгол Улсын хилээр нэвтрүүлсэн тээврийн хэрэгсэл, дүнд эзлэх хувиар, боомтын төрлөөр, жилийн бүрийн эхний улирлын байдлаар



АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР:

Монгол Улсын хилээр нэвтэрсэн зорчигчдод гадаадын болон дотоодын иргэдийг хамруулав. Монгол Улсын хилээр орсон зорчигчдыг зорилгоор нь албаны, хувийн, жуулчлал, дамжин өнгөрөх, суралцах, ажиллах, байнга оршин суух, бусад гэж ангилна.

Жуулчин: Байнга оршин суудаг газраасаа өөр газарт албаны, хувийн, жуулчлал, дамжин өнгөрөх, бусад зорилгоор 183 хоногоос доош хугацаагаар аялж буй гадаадын иргэн юм.

Эх үүсвэр: Хил хамгаалах ерөнхий газар



Мэдээлэл авах линк:

<http://www.nso.mn/>
<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 8 дугаар сарын 15

Хүн ам, нийгмийн статистикийн газрын
дарга А.Амарбал
Утас : (976-51)-264805

Хүн ам, нийгмийн статистикийн газар Хүн
ам, орон сууцны тооллогын товчооны
статистикч Ж.Цогзолмаа
Утас : (976-51)-267547

